



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/477

Булган сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Тусгалтын өндөр" ХХК (РД:3188957)-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 18 дугаар гудамж 1806а тоотод байршилтай 6308005537 нэгж талбар бүхий автомашины засвар, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 700 м² газар, Булган сум 6 дугаар баг Залуус 18 дугаар гудамж 1806б тоотод байршилтай 6308008349 нэгж талбар бүхий үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 700 м² газрын газар эзэмших эрхийг Б.Сэдбаяр (ГБ84042015)-т тус тус шилжүүлсүгэй.

2. Б.Сэдбаяртай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/494 дүгээр захирамжийн "Тусгалтын өндөр" ХХК, 2020 оны А/476 дугаар захирамжийн "Тусгалтын өндөр" ХХК-тай холбогдох хэсгүүдийг хүчингүй болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ